



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДОА-2020/60/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: О.Эрдэнэтуяа

Утас: 7000-3775 Цахим хаяг: edi\_7855@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НӨАТТХ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль



Агуулга

<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	10
3.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	11
3.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	12
3.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
3.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан .....	15
3.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	16

ЧУЛУУНХОРООТ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Л.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

## Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.1. Оршил

Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Л.Мөнхцэцэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 27-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, гэрээт аудитор О.Эрдэнэтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Эрдэм боловсролтой, эерэг сэтгэлгээтэй, эх орондоо хайртай Эрээнцэвчүүдийг төлөвшүүлэх”-д оршино.

Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх
- хүүхдийн хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах
- сайжруулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах
- багшийн ажлын байрандаа хөгжих боломжийг хангах
- сургуулийн орчны аюулгүй байдлыг хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна. Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд AXPLORER программ хангамж ашигладаг байна.

Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 29 эрсдэлтэй асуудалд 29 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 673,382.1 мянган төгрөгөөс тооцон 10,100.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, гүйцэтгэлийн үе шатанд хэвээр баталгаажууллаа.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,368.5 мянган төгрөгөөр буюу 0,7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	131,660.9	140,409.2	8,748.3
Үндсэн хөрөнгө	952,994.8	986,229.9	33,235.1
Элэгдэл	-123,648.2	-159,263.1	-35,614.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>961,007.5</b>	<b>967,376.0</b>	<b>6,368.5</b>
Өр төлбөр			
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	644,486.9	638,407.7	-6,079.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	316,520.6	328,968,3	12,477.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>961,007.5</b>	<b>967,376.0</b>	<b>6,368.5</b>

Авлага, өглөгийн дансны үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн хөгжлийн сангаас багачуудын өргөөний тохижилт 1,200.0 мянган төгрөг, насан туршийн боловсрол танхимын тохижилт 2,486.8 мянган төгрөгийн аж ахуйн материалыг үнэ төлбөргүй авч, батлагдсан төсвөөс 1,946.1 мянган төгрөг, нэмэлт төсвөөс тоглолтын хувцас 2,500.0 мянган төгрөг, камержуулалт 615.4 мянган төгрөгийн аж ахуйн материал худалдан авсантай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь БСШУСЯ-аас ном сурах бичиг 6,774.8 мянган төгрөг, сурагч ширээ, сандал 5,276.9 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас багачуудын өргөөний тохижилт 1,400.0 мянган төгрөг, насан туршийн боловсрол танхимын тохижилт 4,791.4 мянган төгрөг, камержуулалт 4,080.5 мянган төгрөг, халаалтын зуухны засвар 23,319.8 мянган төгрөг, төгсөгчдийн хандиваар тэшүүрийн талбай 19,580.0 мянган төгрөгийн хөрөнгүүдийг үнэ төлбөргүй хүлээн авч, батлагдсан төсвөөс 5,596.8 мянган төгрөг, нэмэлт төсвөөс 400.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор 37,985,1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж акталсан байна.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 328,968,3 мянган төгрөг болж 12,477.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хөрөнгийн орлого, зарлагаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны /нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт/ 6,079.2 мянган төгрөг нь 2008 онд дахин үнэлгээ хийгдсэн хөрөнгийг данснаас хассантай холбоотой байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 583,553.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 583,553.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 546,053.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжих тусгай зориулалтын шилжүүлгээр, 37,500.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 583,222.5 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байна.

**Нэмэлт төсөв:** Туслах үйл ажиллагаанаас 102.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, “Улыбка” чуулгын тоглолтод оролцсон 4 оюутанд урамшуулал болгон олгосон байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 29 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 29 эрсдэл тодорхойлж нийт 29 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 46,649.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 46,649.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

### 1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

Нийт худалдан авалтын 83,5 хувь буюу 46,4 сая төгрөг нь татварын нэгдсэн цахим хуудас дахь ибаримт системд бүртгэгдээгүй байна. Энэ нь *үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж ....., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.*

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

### 2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

Тээвэр шатахууны зардлаас 220.0 мянган төгрөгийг сандал тээвэрлэсэн ажлын хөлсөнд олгосон нь *Төсвийн тухай хуулийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3 “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”* заалтад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

#### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 147 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

#### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэмжлэл авсан байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймгийн Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургууль 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

### 3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>131,660,864.68</b>	<b>140,409,210.35</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	131,660,864.68	140,409,210.35
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	83,215,864.68	86,129,210.35
35420	Аж ахуйн материал	81,417,664.68	84,847,120.35
35440	Тулш, шатах тослох материал	1,402,610.00	1,282,090.00
35460	Хүнсний материал	395,590.00	-
35600	Мал амьтал	48,445,000.00	54,280,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>829,346,629.70</b>	<b>826,966,758.63</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	829,346,629.70	826,966,758.63
<b>392</b>	<b>Биег хөрөнгө</b>	812,546,629.70	810,166,758.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	656,924,327.11	653,126,073.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(27,831,644.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	48,000,000.00	48,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(23,333,333.45)	(31,333,333.49)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	119,009,049.20	119,777,585.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(65,948,737.37)	(61,992,163.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,386,906.69	67,959,263.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,366,098.98)	(36,336,092.70)
39209	Зам, гүүрийн байгууламж	15,000,000.00	34,580,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,565,833.35)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	18,000,000.00	18,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,874,516.50	17,986,928.70
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(204,024.99)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	10,000,000.00	10,000,000.00
<b>393</b>	<b>Биег бус хөрөнгө</b>	16,800,000.00	16,800,000.00
39303	Бусад биег бус хөрөнгө	16,800,000.00	16,800,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b>961,007,494.38</b>	<b>967,375,968.98</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>961,007,494.38</b>	<b>967,375,968.98</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	961,007,494.38	967,375,968.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	367,907,453.88	367,907,453.88
51101	Өмч: - төрийн	351,107,453.88	351,107,453.88
51102	- хувийн	16,800,000.00	16,800,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(51,386,921.50)	(38,939,206.78)
51210	Өмнөх үеийн үр дүн	(51,386,921.50)	(45,307,681.38)
51220	Тайланг үеийн үр дүн	-	6,368,474.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	644,486,962.00	638,407,721.88
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V</b>	<b>961,007,494.38</b>	<b>967,375,968.98</b>

### 3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (D)</b>	<b>561,857,718.00</b>	<b>679,750,597.20</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>30,293,420.00</b>	<b>30,472,200.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	30,293,420.00	30,472,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,293,420.00	30,472,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	30,293,420.00	30,472,200.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>531,564,298.00</b>	<b>649,278,397.20</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	518,899,298.00	649,176,397.20
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	37,500,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	35,454,598.00	65,623,397.20
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	483,444,700.00	546,053,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,665,000.00	102,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	350,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,595,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	720,000.00	102,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>561,144,718.66</b>	<b>661,114,670.80</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>561,144,718.66</b>	<b>661,114,670.80</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>529,683,682.93</b>	<b>645,516,182.80</b>
2101	Цалин хэлс болон нэмэгдэл урамшил	337,718,313.00	424,960,656.00
210101	Үндсэн цалин	223,382,334.00	319,088,943.00
210102	Нэмэгдэл	48,665,700.00	64,157,200.00
210104	Урамшуулал	22,892,832.00	41,714,513.00
210105	Гэрээт ажлын хөлс	42,777,447.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,518,155.27	54,784,400.00
210201	Тэтгэврийн даатгал	30,249,355.27	36,477,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,070,100.00	4,620,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,454,600.00	3,696,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	613,100.00	908,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,131,000.00	9,081,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,603,795.00	32,411,494.00
210301	Гэрэл, цахилгаан	8,361,760.00	8,492,334.00
210302	Түлш, халаалт	23,242,035.00	23,569,160.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	350,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,172,820.00	34,745,104.33
210401	Бичиг хэрэг	333,250.00	1,213,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,480,800.00	2,636,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	658,770.00	681,960.00
210408	Бараа материал акталсны зардал	18,520,000.00	30,013,444.33
2105	Нормативт зардал	25,192,794.01	25,780,412.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	140,000.00	126,000.00
210502	Хоол, хунс	25,052,794.01	25,654,412.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,356,800.00	5,200,000.00
210604	Урсгал засвар	14,356,800.00	5,200,000.00
2107	Томиллолт, зочны зардал	196,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томиллолт	196,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	418,416.00	588,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	238,416.00	588,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэгдэл тогтоох	180,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,506,589.65	65,546,116.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	102,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,897,890.00	4,111,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	51,608,699.65	61,332,616.47



Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,461,035.73	15,598,488.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,981,046.00	15,246,036.00
213205	Төрөөс иргэнд олгох тэтгэмж, урамшуулал	15,498,046.00	15,246,036.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,483,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	479,989.73	352,452.00
213503	Төвлөрүүдэх шилжүүлэг	479,989.73	352,452.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>712,999.34</b>	<b>18,635,926.40</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,847,706.25	12,267,451.80
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,847,706.25	12,267,451.80
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(6,847,706.25)	(12,267,451.80)
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(6,134,706.91)</b>	<b>6,368,474.60</b>

### 3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>496,505,290.00</b>	<b>583,655,000.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>496,505,290.00</b>	<b>583,655,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>483,444,700.00</b>	<b>583,553,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	37,500,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	483,444,700.00	546,053,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>13,060,590.00</b>	<b>102,000.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	350,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,595,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,115,590.00	102,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>496,505,290.00</b>	<b>583,655,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>496,505,290.00</b>	<b>583,655,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>465,044,254.27</b>	<b>568,056,512.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>337,603,304.00</b>	<b>424,960,656.00</b>
210101	Үндсэн цалин	223,267,325.00	319,088,943.00
210102	Нэмэгдэл	48,665,700.00	64,157,200.00
210104	Урамшуулал	22,892,832.00	41,714,513.00
210105	Гэрээт ажлын хөлс	42,777,447.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>44,086,755.27</b>	<b>54,784,400.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	29,481,755.27	36,477,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,654,100.00	4,620,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,921,900.00	3,696,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	729,900.00	908,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,299,100.00	9,081,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>33,253,785.00</b>	<b>32,290,974.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,361,760.00	8,492,334.00
210302	Түлш, халаалт	23,892,025.00	23,448,640.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	350,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,474,320.00</b>	<b>8,249,660.00</b>
210401	Бичиг хэрэг	333,250.00	1,213,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,480,800.00	2,636,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,000.00	200,000.00
210404	Ном, хэвлэл	131,500.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,348,770.00	3,999,960.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>25,588,384.00</b>	<b>29,384,822.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	140,000.00	126,000.00
210502	Хоол, хүнс	25,448,384.00	25,258,822.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	4,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,088,800.00</b>	<b>5,200,000.00</b>
210604	Урсгал засвар	15,088,800.00	5,200,000.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>196,000.00</b>	<b>1,500,000.00</b>
210702	Дотоод албан томиллолт	196,000.00	1,500,000.00



Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	418,416.00	588,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	238,416.00	588,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,334,490.00	11,098,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	102,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,334,490.00	10,996,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,461,035.73	15,598,488.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,981,046.00	15,246,036.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшүүдэл	15,498,046.00	15,246,036.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,483,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	479,989.73	352,452.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	479,989.73	352,452.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	367,907,453.88	644,486,962.00	(51,386,921.50)	-	961,007,494.38
C02	Нягтлан бодох бүртгэлийн боллогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	367,907,453.88	644,486,962.00	(51,386,921.50)	-	961,007,494.38
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	367,907,453.88	644,486,962.00	(51,386,921.50)	-	961,007,494.38
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	367,907,453.88	644,486,962.00	(51,386,921.50)	-	961,007,494.38
D02	Нягтлан бодох бүртгэлийн боллогын өөрчлөлт	-	-	6,079,240.12	-	6,079,240.12
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	367,907,453.88	644,486,962.00	(45,307,681.38)	-	967,086,734.50
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(6,079,240.12)	-	-	(6,079,240.12)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	6,368,474.60	-	6,368,474.60
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	367,907,453.88	638,407,721.88	(38,939,206.78)	-	967,375,968.98

### 3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>583,553,000.00</b>	<b>583,200,548.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>583,553,000.00</b>	<b>583,200,548.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>568,306,400.00</b>	<b>567,954,512.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>425,277,500.00</b>	<b>424,960,656.00</b>
210101	Үндсэн цалин	319,163,300.00	319,088,943.00
210102	Нэмэгдэл	64,157,200.00	64,157,200.00
210104	Урамшуулал	41,957,000.00	41,714,513.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>54,784,400.00</b>	<b>54,784,400.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	36,477,200.00	36,477,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,620,800.00	4,620,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,696,300.00	3,696,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	908,300.00	908,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,081,800.00	9,081,800.00
<b>2103</b>	<b>Байр ашглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>32,300,000.00</b>	<b>32,290,974.00</b>
210301	Гэрэл, сахилгаан	9,320,000.00	8,492,334.00
210302	Түлш, халаалт	22,630,000.00	23,448,640.00
210303	Цэвэр, бохир ус	350,000.00	350,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,250,200.00</b>	<b>8,249,660.00</b>
210401	Бичиг хэрэг	1,213,200.00	1,213,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,637,000.00	2,636,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	200,000.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000,000.00	3,999,960.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>29,406,300.00</b>	<b>29,384,822.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	126,000.00	126,000.00
210502	Хоол, хүнс	25,280,300.00	25,258,822.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,000,000.00	4,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,200,000.00</b>	<b>5,200,000.00</b>
210604	Урсгал засвар	5,200,000.00	5,200,000.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>
210702	Дотоод албан томиллолт	1,500,000.00	1,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>588,000.00</b>	<b>588,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	588,000.00	588,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,000,000.00</b>	<b>10,996,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,000,000.00	10,996,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>15,246,600.00</b>	<b>15,246,036.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>15,246,600.00</b>	<b>15,246,036.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,246,600.00	15,246,036.00